



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*Монгол Улсын Ерөнхий аудитор Ундэсний аудитын газраас 2009 онд
Нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний
дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан*

**Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд
хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн**



**Байгаль орчин, аялал жуулчлал, Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн салбар**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

Агуулга

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгсийн жагсаалт	2
ҮАГ-ын хоёрдугаар газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
<i>Захирал</i>	Бүлэг 1	
<i>Д.Ганбилэг</i>	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг бодитой тооцоогүй байна	
<i>Аудитын менежер</i>	Зарим хөрөнгө оруулалтыг улсын хэмжээнд тэнцүү хуваах зарчмаар хэрэгжүүлж байгаа нь түүний үр өгөөжийг бууруулж байна	5
<i>Х.Баярмаа</i>	Бүлэг 2	
<i>Ахлах аудитор</i>	Зарим худалдан авалтыг журмын дагуу сонгоогүй байна	
<i>С.Сэрчхорол</i>	Худалдан авах ажиллагаанд ил тод байх зарчмыг баримтлаагүй байна	7
<i>Аудитор Ц.Сугармаа</i>	Худалдан авалтын аргыг зөв сонгоогүй байна	8
<i>Ж.Ядмаа</i>	Удирдлага тендерийг илүү үр ашигтай зохион байгуулах боломжийг ашиглаагүй байна	8
<i>Шинжээч Д.Баттулга</i>	Бүлэг 3	
	Гэрээний гүйцэтгэлийг үнэлж, хариуцлага тооцохгүй байна	
	Гэрээгээр хүлээсэн үүргээ зарим байгууллага биелүүлээгүй байна	10
	Ашиглалтад бүрэн ороогүй хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн байна	12
	Бүлэг 4	
	Санхүүжилтийн тогтолцоо, бүртгэл, тайлагнал шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна	
	Хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэсэн ажлын үр дүнтэй уялдахгүй байна	14
	Хөдөө аж ахуйн салбарт 4552,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хувийн хэвшилд хийгдсэн байна	15
	Хөрөнгө оруулалтын ажлыг тайлан тэнцэлд тусгах, бүртгэх талаар хангалтгүй ажиллаж байна	18
	Дүгнэлт	19
	Зөвлөмж	20
	Холбогдох байгууллагын санал	21

Товчилсон үгсийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
МУ	Монгол Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
СЯ	Сангийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААС	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
ХАА	Худалдан авах ажиллагаа
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУХС	Монгол Улсыг хөгжүүлэх сан
ТДС	Тариаланг дэмжих сан
ҮТП	Үйлдвэрлэл технологийн парк
ХО	Хөрөнгө оруулалт
ЖДҮДТ	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
УЦУОХШГ	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний газар
ХХААЖДҮГ	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
УГТЭШХ	Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн
ТББ	Төрийн бус байгууллага
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
СЭЗТСХ	Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХҮГ	Хөнгөн үйлдвэрийн газар
ОНӨА	Орон нутгийн өмчийн алба
ХЗА	Хяналтын зөвлөлийн алба
СС	Сангийн сайд

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Монгол Улсын Ерөнхий Аудиторт ҮАГ-аас 2009 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, тайлагналыг шалгаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитаар “ Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-г БОАЖЯ болон ХХААХҮЯ-ны салбарын хэмжээнд шалгалаа. Үүнд

- ХХААХҮЯ болон БОАЖЯ-нд улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтыг түүвэрлэн шалгахын зэрэгцээ ажил хариуцсан холбогдох ажилтнуудтай ярилцлага хийлээ.
- Тус яамдаас хөрөнгө оруулалтын талаар гаргаж ирүүлсэн судалгааг яам тус бүр дээр судалж шинэчлэн гаргууллаа.
- Салбарын хэмжээний судалгаанаас аймаг, орон нутаг, нийслэлийн аудитын газарт холбогдох материалыг гарган өгч объект дээр нь шалгуулан, үр дүнг тайланд тусгалаа.
- БОАЖЯ болон ХХААХҮЯ-нд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгосон байдал, гэрээний биелэлтийг түүвэрлэн үзэж, шаардлагатай зарим объектыг газар дээр нь үзэж шалгалаа.
- СЯ-наас тус салбар хариуцсан ажилтантай ярилцаж шаардлагатай материалыг тодруулсны зэрэгцээ зарим хөрөнгө оруулалтын талаар тодруулга авлаа.
- БОАЖС болон ХХААХҮС-ын гаргасан тушаал, холбогдох эрхийн акттай танилцаж, шаардлагатай баримт материалыг түүвэрлэн шалгав.
- Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргасан болно.

Бүлэг 1

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг бодитой тооцоогүй байна

1.1 Мянганы хөгжлийн зорилтот суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын “Эдийн засгийн өсөлт, хөгжлийн бодлого”-ын стратегийн зорилт 5.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтыг Мянганы хөгжлийн зорилтуудтай оновчтой уялдуулан нэмэгдүүлж, урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд суурилан хэрэгжүүлнэ” гэж заасан ба 5.2.1.4-т Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогыг 2007-2015 он, 2016-2021 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан байна.

1.2 МУ-ын Засгийн Газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, сүү, гурил, төмс, гол нэрийн хүнсний ногоогоор бүрэн хангах зохион байгуулалтын арга хэмжээ авна гэж тусгасан ба 2008 оныг “Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил” болгон зарласан ажлын хүрээнд Засгийн Газрын 2008 оны 70 дугаар тогтоолоор “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг баталжээ.

1.3 УИХ-ын 2003 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого болон Эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд газар тариалангийн талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх үндсэн зорилгод уг хөтөлбөр нь тулгуурласан байна.

1.4 “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын болон орон нутгийн төсөв, банкны зээл, гадаад орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, иргэний хөрөнгө оруулалтыг эх үүсвэр болгон ашиглахаар тусгажээ.

1.5 ХХААХҮЯ дээрх бодлого, хөтөлбөрийн хүрээнд 2009-2011 онд баримтлах дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулсан гаргасан байна.

1.6 БОАЖЯ “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Ойжуулалт”, “Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тундас оруулах”, Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарыг 2015 он хүртлэх хугацаанд хөгжүүлэх” хөтөлбөрүүдийг үндэслэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулжээ.

1.7 2008 онд ХХААХҮЯ-нд хөрөнгө оруулалтаар улсын төсөв болон МУХС, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэр болон өөрийн хөрөнгөөр 55471,0 сая, БОАЖЯ-ны хөрөнгө оруулалтад улсын төсөв, МУХС болон гадаадын зээл тусламж болон бусад эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 6966.3 сая төгрөг тус тус төлөвлөгдсөн байна. (Хавсралт 1)

ХХААХҮЯ болон БОАЖЯ-ны хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал:
(Сая төгрөгөөр)

ХХААХҮЯ				БОАЖЯ	
№	Эх үүсвэр	Санхүүжигдэх хөрөнгийн дүн	Хувь	Санхүүжигдэх хөрөнгийн дүн	Хувь
1	Улсын төсөв	15459.8	27,9	6128.0	87,9
2	МУХС	28465.1	51,3	384,3	5,5
3	Гадаадын зээл, тусламж	6535.6	11,7	99,1	1,4
4	Өөрийн хөрөнгө	2676.0	4,8	328,6	4,7
5	Бусад эх үүсвэр	2334.5	4,3	5,8	0,08
6	Орон нутаг	-		20,5	0,29
	Нийт дүн	55471.0	100	6966,3	100

1.8 Монгол Улсын 2008 оны Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 23333.3 сая төгрөгийн хөрөнгийг МУХС-гаас санхүүжүүлэхээр баталжээ.

1.9 Дээрх хөтөлбөрийн хүрээнд Засгийн Газрын 2008 оны “Төсөл хэрэгжүүлэх тухай” 136 дугаар тогтоолоор шинээр тариалан эрхлэгчдэд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, арчлах, хураах, хадгалах технологийг зааж сургах, техникээр үйлчлэх болон иргэдийн орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Агропарк” төслийг хэрэгжүүлэхээр баталж, сургалт сурталчилгааг ТББ-ын оролцоотойгоор зохион байгуулахыг ХХААС (хуучнаар)-д, сум, дүүрэгт агропарк байгуулах ажилд дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан байна.

1.10 ХХААХҮ-ийн салбарт гадаад орон болон олон улсын байгууллагуудын буцалтгүй тусламжаар 24, хөнгөлөлттэй зээлээр 1 төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна.

Зарим хөрөнгө оруулалтыг улсын хэмжээнд тэнцүү хуваах зарчмаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь түүний үр өгөөжийг бууруулж байна

1.11 ХХААХҮЯ усны цооног өрөмдөх, худгийн барилгын ажилд дотоодын болон импортын бараа, бүтээгдэхүүний үнийн болон цалингийн өсөлт, инфляци зэргийг тооцож үнийн зохицуулалт хийсэн байна. Үүнд, 50 метр гүнтэй худгийг улсын дундаж гэж үзэж 12.5-14.5 сая төгрөгөөр худгийн цооног өрөмдөх, уст цэг тогтоох хайгуул, тээврийн зардал, ус шахуурга, цахилгаан үүсгүүр, худгийн барилга, усан сан, халаалтын зуух, мал услах онгоц, цооногт суулгах суултын яндан, шүүр худалдан авах болон өрөмдлөгийн суурь машин, компрессор, яндан штанг, тээврийн болон ажлын хөлс, нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвар зэргийг нэг бүрчлэн тооцсон байна.

1.12 Гэтэл зарим төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил, үйлчилгээг аймаг, орон нутгийн онцлогийг харгалзалгүй, төсөвт өртгийг бодитой тооцолгүй, урьдчилсан судалгаагүйгээр улсын хэмжээнд засаг захиргааны анхан шатны нэгж бүрт жигд хэрэгжүүлэн

шууд санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа нь түүний ач холбогдлыг бууруулж, үр ашиггүй хөрөнгө оруулалт хийгдэх нөхцөл бүрдүүлж байна. Тухайлбал,

- “Агропарк” төслийг хэрэгжүүлэхэд нийт 3841.0 сая төгрөг батлагдсан боловч улсын хэмжээний 334 сум бүрт 11.5 сая төгрөгийн (үүнд 5.0 сая төгрөгийн зоорь, 2.5 сая төгрөгийн хүлэмж, 4.0 сая төгрөгийн бага оврын трактортай байх) хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөжээ. Цаашид ийм хөрөнгө оруулалтын арга хэмжээг тодорхой судалгааны үндсэн дээр нэг хэсэг газар хэрэгжүүлж, тэдгээрийн туршлагад үндэслэн өөр байршилд өргөжүүлэн хэрэгжүүлэх нь илүү өгөөжтэй юм.
- БОАЖЯ 21 аймаг бүрт 7 булаг шандын эхийг хамгаалахад (нэг булаг шандыг хамгаалахад 1.5 сая төгрөгөөр тооцон) нийт 217.0 сая төгрөг төлөвлөжээ.
- 2008 онд услалтын систем шинээр барьж байгуулахад 1 га талбайд 5.0 сая төгрөгөөр тооцож, (өөрийн хөрөнгө оруулалтаар 2.7 сая, улсын төсвөөс 2.3 сая төгрөг) нийт 4580.0 сая төгрөг төлөвлөсөн боловч өртөг тооцох аргачлал, норм норматив, стандарт байхгүйгээс бодитой тооцсон эсэхийг тогтоох боломжгүй байна.
- Салбарын хэмжээнд өмнөх онуудад хөрөнгө оруулалт хийгдсэн зарим барилга байгууламжид шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг дутуу тооцсон, бодитой төлөвлөөгүйгээс хөрөнгө дутагдаж он дамжсаар илүү их хөрөнгө шаардагдах нөхцөл бий болжээ. Тухайлбал, Хэнтий аймгийн ХХААЖДҮГ-ын барилгад 2007 онд 50.0 сая, Баян-Өлгий, Увс аймгийн БОА-ны барилгад 2007- 2008 онд 55.0-70.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн боловч хөрөнгө мөнгөний эх үүсвэр дутагдсанаас өнөөг хүртэл дуусаагүй байна.
- Зарим хөрөнгө оруулалтыг эдийн засгийн болон экологийн суурь судалгаа, шинжилгээ, аймаг, орон нутгийн санал, хүсэлт, онцлогийг бүрэн тусгахгүйгээр төлөвлөдөг явдал арилахгүй байна.
- МУ-ын Шадар сайдын багцаас ХХААХҮ-ийн салбар болон БОАЖ-ын салбарын хөрөнгө оруулалтад 500.0 сая төгрөгийг МУХС-гаас дараа онд баригдах барилга байгууламж, төсөл арга хэмжээний ТЕЗҮ боловсруулах, зураг төсөө хийх зориулалтаар шууд санхүүжүүлэхээр болжээ.

Бүлэг 2

Зарим худалдан авалтыг журмын дагуу зохион байгуулаагүй байна

2.1 2008 онд ХХААХҮЯ нээлттэй тендерээр 42, хязгаарлагдмал тендерээр 2, харьцуулалтын аргаар 5, шууд гэрээгээр 2, БОАЖЯ нээлттэй тендерээр 29, харьцуулалтын аргаар 98, шууд гэрээгээр 5 удаа бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажил зохион байгуулж, тендер зарласан байна.

ХХААХҮЯ, БОАЖЯ тендер зарлах хүртлэх бэлтгэл үе шатны болон гүйцэтгэгч сонгох ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан ба хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслийн тендер шалгаруулах урилгуудыг өдөр тутмын сонинд тавьж, хязгаарлагдмал тендерийн урилга болон үнийн саналыг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн байна. Гэвч ХХААХҮЯ болон БОАЖЯ зарим бараа ажил үйлчилгээг худалдан авахад дараахь нийтлэг зөрчил гарсан байна.

Худалдан авах ажиллагаанд ил тод байх зарчмыг баримтлаагүй байна

2.2 Бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмын тухай хуулийн ил тод байх зарчим алдагдаж байна. Тухайлбал, ХХААХҮЯ болон БОАЖЯ-ны хэмжээнд 7591.1 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.

- Газар тариалангийн гол бүс нутагт цаг агаарт зориудаар нөлөөлөн хур тунадас нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийг зөрчин “Хурын шим” ХХК-тай 142.5 сая төгрөгийн шууд гэрээ байгуулжээ.
- БОАЖС, ТНБД нарын тушаалаар “Цөлжилттэй тэмцэх арга хэмжээ”, Ойжуулалтын арга хэмжээ”, “Химийн хорт бодисыг хоргуйжүүлэх арга хэмжээ” зэрэг төсөл, арга хэмжээний 6538.5 сая төгрөгийг тендер зарлалгүйгээр шууд гэрээ хийн зарцуулжээ.
- БОАЖЯ-ны харьяа Богд Хан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа 2007 оны төлөвлөгөөнөөс давсан орлогоос байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж хуваарилсан 110.1 сая төгрөгөөр 121.8 м² талбай бүхий 250.0 сая төгрөгийн байрыг шууд гэрээ хийн дараа тооцоогоор худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчжээ.
- Архангай аймгийн ХХААЖДҮГ “Агропарк” төслийн 5.7-д “зоорь, хүлэмж барих ажлыг тухайн нутаг дэвсгэрийн цаг агаарын онцлогт тохируулан төсөвт өртөгт багтаан сум, дүүргийн ЗДТГ зохион байгуулна” гэж заасныг зөрчиж, 5 сумаас бусад сумдын 105.0 сая төгрөгийн санхүүжилтийг зарим аж ахуйн нэгж, иргэнд гэрээтэй болон гэрээгүй олгосноос хөрөнгөд тавих хяналт алдагдаж, ашиглалтын үр өгөөж буурсан байна.

- “Услалтын систем сэргээн засварлах, шинээр барьж байгуулах төсөл шалгаруулах” тендерийг зохион байгуулж хэрэгжүүлэхэд зарим аж ахуйн нэгж гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон, гүйцэтгэгч нас барсан зэрэг шалтгаанаар зарцуулагдаагүй 445.0 сая төгрөгийг ХХААХҮС-ын тушаалаар нэр бүхий 13 аж ахуйн нэгжид ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр шууд олгожээ.

2.3 Олон нийтэд ил тод байлгах зорилгоор цахим хуудсанд босго үнэ давсан тендерийн урилга болон үр дүнг нийтлэх ёстой боловч 2008 онд Сангийн яамны вебсайтад бүрэн гүйцэд нийтлээгүй байна. Тухайлбал, ХХААХҮЯ тендерийн урилга 27, тендер шалгаруулалтын үр дүн 34, БОАЖЯ тендерийн үр дүнг вебсайтад байрлуулаагүй байлаа.

Худалдан авалтын аргыг зөв сонгоогүй байна

Аудитын явцад хийсэн түүвэрлэлтээр 7660.0 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээний худалдан авах аргыг буруу сонгосон байна.

- *Атрын гурав дахь аян” тариалангийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд усалгаатай тариаланд дэмжлэг үзүүлэх зорилгоор МУХС-гаас 5960.0 сая төгрөгийг “нээлттэй тендер” зарлан услалтын систем шинээр барьж байгуулах 46, сэргээн засварлах 52 аж ахуйн нэгж, иргэдэд олгожээ.*
- *УЦУОХШГ 1700.0 сая төгрөгийн цаг уурын багаж тоног төхөөрөмжийг хэд хэдэн багц болгож нэг тендер зарлах ёстой атал үнийг олон хэсэг хувааж, тоног төхөөрөмжийг харьцуулалтын аргаар худалдан авснаар ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.5 дахь заалтыг зөрчсөн байна.*

Удирдлага тендерийг илүү үр ашигтай зохион байгуулах боломжийг ашиглаагүй байна

2.4 ХХААХҮЯ, БОАЖЯ 632.4 сая төгрөгийн тендерийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зохион байгуулах боломж байжээ.

- *ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6.45.4-т “тодорхой нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ нэгдсэн журмаар худалдан авах нь хэмнэлттэй бөгөөд үр ашигтай бол 2 болон түүнээс дээш захиалагч худалдан авах ажиллагааг төвлөрүүлэн, эсвэл хамтран зохион байгуулж болно” гэж заасныг зөрчиж, БОАЖЯ болон УЦУОХШГ-т 183.6 сая төгрөгийн 220 ш мотоцикл худалдан авахдаа тус тусад нь тендер зарласнаас 20 мотоциклийн үнийн зөрүү 8.0 сая төгрөгийн үр ашиггүй зардал гарчээ.*
- *БОАЖЯ-д 93.3 сая төгрөгийн УАЗ-31512 маркийн 7 автомашин, УЦУОХШГ-т 160.6 сая төгрөгийн УАЗ-3909 маркийн 11 автомашин худалдан авахдаа тус тусад нь тендер зарласан байна.*
- *Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан услалтын системийг байгуулахад тендерийн босго үнийг 150.0 сая төгрөгөөр тооцсон атал 194.9 сая*

төгрөгийн санал ирүүлсэн “Эм Ти Эс Даблью Ар” ХХК-ийг шалгаруулж ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчжээ.

- Усалгаатай тариалангийн хайгуул судалгаа хийх зөвлөх үйлчилгээний тендерт 8 аж ахуйн нэгжийг шалгаруулсны дараа ХХААХҮЯ “тендер зарлах зөвшөөрөл авах тухай” албан бичиг Сангийн яаманд хүргүүлсэн байна. Үүнд, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу манай яамнаас тендер зарлах зөвшөөрөл авах ёстой байсан боловч авалгүйгээр тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна. Уг тендер шалгаруулалтын ажиллагаа явагдаж тухайн төсөл арга хэмжээний санхүүжилт хийгдэж эхэлсэн тул зөвшөөрөл өгөх боломжгүй” гэсэн хариу өгчээ.*

2.4 Дээрх байдлаас үзэхэд ХХААХҮЯ болон БОАЖЯ ТБОНӨХБАҮХАТХ- ийн дагуу төсөл тус бүрт үнэлгээний хороог байгуулсан боловч зарим ажил, үйлчилгээ, бараанд худалдан авалтын аргыг зөв сонгоогүй, ил тод байх зарчмыг баримтлаагүй, үр ашигтай зохион байгуулах боломжийг алдсан байна.

Бүлэг 3

Гэрээний гүйцэтгэлийг үнэлж, Хариуцлага тооцохгүй байна

- 3.1 ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу БОАЖЯ болон ХХААХҮЯ тендерт шалгарсан аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулан ажиллаж иржээ.
- 3.2 Зарим аж ахуйн нэгж байгууллага гэрээний үүргээ сайн биелүүлж, хөтөлбөр арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.

- “Гацуурт” ХХК, “Их таян” ХХК, Өмнөговь аймгийн Булган сумын ЗДТГ-ын харьяа услалтын системд олгосон хөрөнгийг үр дүнтэй ашигласан байна.
- Завхан аймаг “Агропарк” төслийн хүрээнд хийгдэх зоорь болон хүлэмжийг бүрэн байгуулж, сум бүрт бага оврын тракторыг хүлээлгэн өгчээ.
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд Тужийн нарсны 1140 га газарт ойжуулалт, ойн арга хэмжээ сайн хийгджээ.

Гэрээгээр хүлээсэн үүргээ зарим байгууллага биелүүлээгүй байна



2.2 Захиалагчийн зүгээс байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлэх, гүйцэтгэгчтэй хариуцлага тооцох явдал хангалтгүй байна. Тухайлбал, “Агропарк” байгуулах төслийн хүрээнд улсын хэмжээнд 334 суманд зоорь барихаар олгосон хөрөнгийг шалгахад 27 сум огт эхлээгүй, 110 суманд дутуу барьсан нь уг төсөл хангалтгүй хэрэгжиж байгааг харуулж байна.

- ХХААХҮЯ-наас Архангай аймгийн ХХААЖДҮГ-т “Агропарк” төслийн хүрээнд шаардагдах хөрөнгийг 2008 оны 6 дугаар сарын 5-нд шилжүүлсэн бөгөөд тус газар 3 сарын дараа “Ар Цүүр” нөхөрлөлтэй 11 суманд зоорь барих гэрээ хийсэн боловч өнөөгийн байдлаар гэрээний биелэлтийг тооцоогүй, хүлээлгэн өгсөн гүйцэтгэлийн акт байхгүй учраас аймгийн аудитын газар 45.0 сая төгрөгт албан шаардлага өгч, 2.0 сая төгрөгт төлбөрийн акт тавьжээ.
- Төв, Дорноговь, Хэнтий, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Дархан-Уул, Булган, Орхон аймгуудын зарим сумдад зоорь гүйцэт баригдаагүй, чанар стандартын шаардлага хангаагүйн дээр зарим суманд бэлэн зоорь худалдаж авсан, зарим сумдын ЗДТГ-ын дансанд мөнгө нь байршиж байна.
- Төслийн хүрээнд олгогдох бага оврын трактор 2008 онд гүйцэд тараагдаагүй, одоо болтол аваагүй сум ч байна. Тухайлбал, Ховд аймгийн Мянгад, Жаргалант сум трактораа хүлээж аваагүй байна.
- Мөн Орхон аймгийн Жаргалант суманд уг тракторыг тамгын газарт хог ачих зориулалтаар ашиглаж байлаа.

3.4 Зарим аймаг, сумдын ЗДТГ-ын ажилтнууд “Агропарк” төслийн зорилгыг мэдэхгүй, цогцолбор хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахгүй байгаагийн зэрэгцээ биелэлтийг хангуулах талаар яамны зүгээс тодорхой арга хэмжээ аваагүй, энэ ажил цаг хугацааны хувьд оновчгүй, хөрөнгө оруулалтын ажлын үр нөлөө тодорхойгүй, үр дүн муутай зохион байгуулагдсан байна.

3.5 “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд 160 морины хүчин чадалтай УТО-1604 трактор 110 ширхгийг нийлүүлэх тендерт “Шандас групп” ХХК шалгарч, 2008 оны 10 дугаар сарын 6-нд нийлүүлэхээр гэрээ байгуулсан боловч тайлант онд 20 ширхэг трактор нийлүүлж гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй байна.

3.6 БОАЖЯ-наас зарласан 7 аймагт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй, шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй байлаа. Тухайлбал, Завхан аймгийн БОА-нд 26.2 сая төгрөгийн хогийн машин, 62.0 сая төгрөгийн трактор, 24.0 сая төгрөгийн үнэтэй электрон пүүг бэлтгээгүй байна.

3.7 Гэрээнд заасан хугацаанд услалтын системийг шинээр байгуулах ажлыг бүрэн хийж дуусаагүйгээс Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ буудай” ХХК, “Монгол Зөгий” ХХК, “Хайрхан оргил уул” ХХК-иуд улсын комисст ажлаа хүлээлгэж өгөөгүй, услалтын системийг сэргээн засварлах гэрээгээр хүлээсэн үүргээ иргэн Ш.Батноров, Л.Бямбажав нар бүрэн биелүүлээгүй байна.

3.8 Хэнтий аймагт 200.0 сая төгрөгөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах сүүний үйлдвэрийн тендерт “Оргил констракшн” ХХК шалгарч санхүүжилтээ бүрэн авсан боловч тоног төхөөрөмж нь өнөөдрийг хүртэл нийлүүлэгдэж дуусаагүй байна.



3.9 Хамрын хийдийн аялал жуулчлалын цогцолборын тусгай хамгаалалттай газрын жуулчин хүлээн авах 69.9 сая төгрөгийн өртөгтэй мэдээллийн төв барихаар ЗТАЖЯ (хуучнаар) “Хөхий хан” ХХК-тай 2008 оны 9 дүгээр сарын 3-нд гэрээ байгуулжээ.

3.10 Гэрээнд зааснаар уг барилга 2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр бүрэн дуусч улсын комисст хүлээлгэн өгөх байсан боловч барилгын цахилгаан, сантехникийн асуудал шийдэгдээгүй барилгын ажил дутуу байна. Барилгыг орон нутгийн тусгай хамгаалалттай бүсэд барьснаас газрын асуудал шийдэгдээгүй, улсын комисс хүлээн аваагүй

байхад санхүүжилтийг 100 хувь хийсэн байна.

Ашиглалтад бүрэн ороогүй хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн байна.

2.3 2937.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг гүйцэтгээгүй байхад БОАЖЯ болон ХХААХҮЯ санхүүжилтийг олгосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Зориулалт	(сая төгрөгөөр)	
		Тоо	Үнийн дүн
1	Зоорь	137	685.0
2	Хүлэмж	169	422.5
3	Худаг		433.0
4	Услалтын систем	16	1127.9
5	Барилга байгууламж	2	269.9
Нийт дүн			2937.8

Гүйцэтгэл дутуу байхад санхүүжилт олгосон жишээнээс дурдвал:

- БОАЖЯ “Талст ширээт” ХХК-тай тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагчдын уналгын 84 морийг 29.4 сая төгрөгт нийлүүлэхээр гэрээ байгуулж хүлээн авсан акт байгаа боловч аудитын явцад Баян-Өлгий, Ховд, Увс, Хөвсгөл, Хан хэнтий ТХГ-ын захиргаад уналгын морио аваагүй, харин бэлэн мөнгө авсан байна.
- Төв аймгийн Сүмбэр сумын “Хадат толгой”-д худаг гаргаагүй байхад 2008 оны 10 дугаар сарын 20-нд Төв аймгийн ажлын комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж “Сайн” үнэлгээтэй хүлээлгэн өгсөн хуурамч баримт бүрдүүлснээр санхүүжилт авсан байна.
- Тус аймгийн Борнуур, Сүмбэр, Мөнгөнморьт сумдад зоорины ажил эхлээгүй атал сумдын үнэлгээний хороо хуралдаж хүлээн авсан тухай хурлын тогтоол, ашиглалтад оруулах техникийн комиссын акт үйлдсэн байна.
- Дундговь аймагт шинээр худаг гаргах тендерт шалгарсан “БИ-ГАРМ” ХХК ус гараагүй гэдэг шалтгаанаар тендерийн нөхцөлийг өөрчлөн хуучин худаг засварлаж шинэ худгийн санхүүжилт авсан нь илэрсэн тул зөрүүг тооцон Аймгийн аудитын газар 7.9 сая төгрөгт төлбөрийн акт тогтоожээ.
- Өвөрхангай аймгийн “Баянговь” ХХК шинээр барих худгийг хийгээгүй, ажлын гүйцэтгэл тооцоогүй байхад аймгийн СЭЗТСХ 25.0 сая төгрөгийг шууд санхүүжүүлсэн байна.
- Дархан-Уул аймагт “Мичидмарал” ХХК, “Дархан гидрогео” ХХК-дад шинээр барих худгийн санхүүжилтийн урьдчилгааг илүү олгосон ч гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй хуурамч гүйцэтгэл гаргасан байлаа.
- “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх техникийн шинэчлэлт хийх арга хэмжээний хүрээнд тендерээр ХТЗ-150 К-09 трактор 80 ш, 120 м/х-тэй трактор 45, 160 м/х-тэй ЮТО трактор 30 ш, 35 м/х-тэй трактор 80 ш, Лидер-6Н сийрүүлүүр 75 ш, ОП-18 хор цацагч 22 ш, үрлэгч 95 ш, АФ-6150 комбайн 41 ш, нийт 17.8 тэрбум төгрөгийн техник тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнийг газар тариалангийн аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлээр олгож, уринш боловсруулалт, тариа

хураалтын өмнө нийлүүлжээ. Дээрх тоног төхөөрөмж, трактор нийлүүлэх тендерт “Агромаштех” ХХК, “Өлзий төв”, “Сансар кабелийн телевиз”, “Шандас групп” ХХК-ууд шалгарсан ба нийлүүлсэн техникийн чанарын талаар сонин хэвлэл, телевизээр удаа дараа гомдол гарч байгаа тул яамны зүгээс энэ асуудлыг судлан үзэж, холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байна.

- БОАЖЯ-ны төвлөрсөн арга хэмжээний зардлаас Байгаль хамгаалалттай холбоотой цуврал баримтат кино хийхээр чөлөөт уран бүтээлч Б.Догмид 2008, 2009 онд төлөвлөсөн 17.5 сая төгрөгийг урьдчилан авсан боловч киног энэ онд дуусгахаар ажиллаж байна.
- Дорноговь аймгийн Айраг, Дэлгэрэх, Даланжаргалан суманд “Цөлжилтийн эсрэг ногоон зурвас” байгуулахаар 1.4 сая төгрөг олгосон боловч ямар ч ажил хийгдээгүй тул буцааж төлүүлэхээр Аймгийн аудитын газар акт тогтоожээ.
- Сэлэнгэ аймгийн ХХААЖДҮГ инженерийн хйицтэй худаг, уст цэг шинээр гаргах хяналтын зардал 2.5 сая төгрөгийг авсан боловч ажлын явц гүйцэтгэлд нэг ч удаа хяналт тавиагүй байна.

Бүлэг 4

Санхүүжилтийн тогтолцоо, бүртгэл, тайлагнал шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна

2008 онд ХХААХҮЯ 50785.3 сая, БОАЖЯ 6966.3 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зориулалтаар санхүүжүүлжээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Эх үүсвэр	БОАЖЯ	ХХААХҮЯ	Нийт дүн (сая төгрөгөөр)
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	6128.0	15223.7	21351.7
2	МУХСангийн хөрөнгө оруулалт	384.3	26760.4	27144.7
3	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	20.5	-	20.5
4	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалт	99.1	3994.1	4093.2
5	Өөрийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт	328.6	2499.1	2827.7
6	Гишүүдийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэр	5.8	2308.0	2313.8

Дээрх хүснэгтээс үзэхэд нийт хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг МУХС, төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлжээ.

Хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэсэн ажлын үр дүнтэй уялдахгүй байна

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын үе шат бүрт тавих хяналт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

2008 онд БОАЖЯ болон ХХААХҮЯ-ны хэмжээнд 57751.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт гүйцэтгэгдсэнээс ашиглалтад ороогүй болон гүйцэтгээгүй ажлыг санхүүжүүлсэн, гэрээнд заасан хугацаанд худалдан авах техник, тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй, ажлаа хийж дуусгаагүй, хөрөнгө оруулалтаар худалдан авсан боловч бүрэн хэмжээнд ашиглагдахгүй байгаа барилга байгууламжийг тооцож үзвэл ХХААХҮЯ 13.4 хувь, БОАЖЯ 0.3 хувийг тус тус эзэлж байна. (Хавсралт 2)

- “Агропарк” төслийн хүрээнд олгосон МУХС болон ТДС -гаас зарцуулсан уг хөрөнгийг шууд зардалд оруулан тооцож, эргэж хяналт тавих асуудлыг орхигдуулснаас уг төсөл хангалтгүй хэрэгжжээ.
- ХХААХҮЯ хөрөнгө оруулалтын тайландаа “Шандас групп” ХХК-иас нийлүүлэх 110 тракторыг бүрэн нийлүүлснээр гаргажээ. Дээрх тракторыг худалдаж авах хөрөнгийн үлдэгдэл 3890.3 сая, мөн “Био бордооны техник тоног төхөөрөмж” худалдан авахаар хөрөнгө оруулалтаар батлагдсан 500.0 сая, бүгд 4390.3 сая төгрөгийг төгрөгийг улаан буудай худалдан авахад зарцуулсан тул уг эх үүсвэрийг нөхөн бүрдүүлэх албан шаардлага өглөө.

- *"Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд үржлийн цаа буга худалдан авах 80.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй, мөнгө нь Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын дансанд байна.*

УИХ-ын 2003 оны 54 дүгээр тогтоолын 6.1.4-т "ҮТП байгуулах үнэлгээ хийлгэх, төлөвлөгөө, төсөл боловсруулах ажлыг зохион байгуулж, эдгээрт шаардагдах санхүүгийн дэмжлэг"-ийг төрөөс үзүүлэхээр заажээ.

Энэ үндсэн дээр ҮХЯ (хуучнаар) Дархан-Уул, Орхон, Говь-Алтай, Завхан аймаг, нийслэлд ҮТП, ЖДҮДТ байгуулахаар худалдан авсан зарим барилга байгууламж нь өртөг өндөртэй, ашиглалтгүй, шаардлага хангахгүй, төрийн өмчид бүртгэгдээгүй байна.

- *Орхон аймагт ҮТП-ын захиргааны конторын зориулалтаар ашиглах барилга нийлүүлэх тендерийг 2 удаа зарласан боловч шаардлага хангасан тендер ирээгүй тул зохих хуулийн дагуу шууд гэрээ байгуулахаар 3 компаний санал авч иргэн Г.Дамиранбазарын барилгыг сонгон шалгаруулжээ. Уг объект нь нийтийн эзэмшлийн газарт баригдсан, өндөр үнэтэй байсан бөгөөд зөвхөн 2 дугаар давхрыг худалдаж авсан боловч 2 давхар барилга хүлээлцсэн мэтээр зөрүүтэй акт үйлджээ.*
- *Гэрээний дагуу 240.0 сая төгрөгийг 2008 оны 12 дугаар сарын 17-нд шилжүүлсэн ч ХХААХҮЯ-аас үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн хураамжийг төлөөгүй гэсэн шалтгаанаар уг хөрөнгө өнөөдрийг хүртэл иргэний өмчлөлөөс шилжээгүй бөгөөд эзэмшил газрын асуудал тодорхой бус байна.*
- *Дархан-Уул аймагт ҮТП байгуулах зорилгоор байрлал зохимжгүй, төвлөрсөн халаалтгүй барилгыг 240.0 сая төгрөгөөр буюу орон нутгийн хувьд нилээдгүй өндөр үнээр худалдан авсан нь одоогоор ямар ч ашиглалтгүй, харуулын цалинг орон нутгийн төсвөөс гаргаж байгаагаас үзэхэд цаашдаа юунд ашиглах нь тодорхойгүй байна.*
- *Тус аймгийн ЖДҮДТ-ийн конторын зориулалттай барилгыг "Дархан Сондор трейд" ХХК-иас 399.5 сая төгрөгөөр худалдан авч тайлан тэнцэлдээ тусгасан боловч өмчлөх эрх нь шилжигдээгүй он дамжжээ.*

Дээрх байдлаас харахад ҮХЯ (хуучнаар)-наас ХХААХҮЯ-нд шилжин очих барилга байгууламж данс бүртгэл, тайлан тэнцэлд бүрэн тусгагдаагүй байна.

4552,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хувийн хэвшилд хийгдсэн байна

Улсын төсвөөс худаг сэргээн засварлах, шинээр гаргахад сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээний хөрөнгө гаргасан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

1998-2008 онд сэргээн засварласан худаг		2004-2008 онд шинээр барьсан худаг	
Тоо	олгосон хөрөнгө	тоо	олгосон хөрөнгө
2902	7 135.0	1959	19 988.3



Сүүлийн 10 жилд улсын хэмжээнд худаг сэргээн засварлах, шинээр барихад төсвөөс 27123.3 сая төгрөг зарцуулжээ.

Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд Архангай, Булган, Хөвсгөл, Хэнтий аймгуудад 2004-2008 онд 394 худгийг сэргээн засварлахад 1098.2 сая, шинээр гаргасан 120 худагт 1309.1 сая, бүгд 2407.3 сая төгрөг зарцуулсныг тооцож үзвэл сүүлийн жилүүдэд төсвөөс болон төслийн хүрээнд 3300 худгийг сэргээн засварлаж, 2079 худгийг шинээр гаргахад нийтдээ 29530.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Зөвхөн 2008 онд инженерийн хийцтэй худаг шинээр гаргахад 7884.6 сая, худаг сэргээн засварлахад 1000.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, аймаг, нийслэл, отрын бүс нутагт 672 худаг шинээр гаргаж, 16 аймагт 215 худаг сэргээн засварлаж ашиглалтад хүлээн авснаар 1,3 сая га бэлчээрийг усжуулах, 2,5 сая мал сүрэг, 3500 гаруй малчин өрхийг усаар хангах боломжийг бүрдүүлсэн байна.

Гэвч худаг шинээр гаргах, сэргээн засварлахад улсын төсвөөс олгож байгаа хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналт шаардлагын хэмжээнд хүрч чадахгүй байна.

- *Архангай аймагт 2008 онд шинээр барьж байгуулсан 11 худаг, засвар хийсэн 1 худгаас ус гарахгүй, моторын хүчин чадал хүрэхгүй, мотор эвдэрсэн гэсэн шалтгаанаар ашиглалтгүй байна. Өөрөөр хэлбэл, тус аймагт худаг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулсан 136,6 сая төгрөг үр ашиггүй зарцуулагджээ.*
- *Ховд аймгийн Чандмань суманд “Шанд булаг” ХХК, “Эвлэл” ХХК -уудын гаргасан худаг чанарын шаардлага хангаагүй, гэрээнд зааснаас өөр газар барьсан, оролцооны мөнгө өгөөгүйгээс худгийн ашиглалт хангалтгүй байгаа тул аймгийн аудитын газраас 110.4 сая төгрөгийн албан шаардлага өгчээ.*
- *Говь-Алтай аймагт “Хүрд” ХХК 94.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 худгийг гаргаагүй, Өвөрхангай аймгийн “Баянговь” ХХК шинээр гаргах 4 худгийг хагас дутуу хүлээлгэж өгсөн боловч одоо болтол дуусгаагүй байна.*
- *Говьсүмбэр аймагт “Цахиур баян” ХХК шинэ худаг гаргахаар тендерт оролцон гэрээ байгуулчихаад хуучин худаг засварлахаар болсон атлаа гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, гэрээний үнийг өөрчлөөгүй байлаа. ХХААС-ын 2008 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 1\633 дугаар албан бичгээр тус аймагт шинээр гаргах худгийн дундаж үнийг 11.0 сая, сэргээн засварлах худгийн дундаж үнийг 4.5 сая төгрөгөөр тус тус тооцож төлөвлөхийг зөвлөсөн боловч дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал, 4 шинэ худаг гаргахаас 1 шинэ худаг гаргаж, хуучин 3 худгийг сэргээн засварласан ба шинэ худгийг 11.8 сая төгрөгөөр, хуучин худгийг 12.0 сая төгрөгөөр сэргээн засварласан тул зөрүү 22.6 сая төгрөгийг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэжээ.*

Дээрх байдлаас үзэхэд худаг, уст цэг шинээр гаргах, худаг сэргээн засварлахад зарцуулах хөрөнгөд тавих хяналт суларчээ. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн худгийг орон нутгийн өмчид шилжүүлэн, бүртгэлд тусгаж, хариуцах эзэнтэй болгох шаардлагатай байна.



Сүүлийн 5 жилд услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах зорилгоор 116 аж ахуйн нэгж, иргэдэд дэмжлэг, тусламжаар 9157.5 сая төгрөг олгожээ.

Зөвхөн 2008 онд услалтын систем шинээр барих 38 аж ахуйн нэгжид 5145.9 сая, сэргээн засварлах 22 аж ахуйн нэгж, 30 иргэнд 1314.0 сая, услалтын систем шинээр барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөл боловсруулахад 392.0 сая, бүгд 6851.6 сая төгрөг зарцуулжээ. Үүнээс 4552,9 сая төгрөгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдэд “дэмжлэг” нэрээр

буцалтгүй тусламж болгон олгосон байна.

Улсын хэмжээгээр тариалсан нийт талбайн 14.5 хувийг усалгаатай тариалан эзэлж байгаагийн дотор үр тарианы талбайн 4.28 хувь, төмсний талбайн 74.2 хувь, хүнсний ногооны талбайн 96.6 хувь, малын тэжээлийн талбайн 97.3 хувь усалгаатай байна.

ХХААХҮЯ-наас авсан судалгаанаас үзэхэд 2008 онд усалгаагүй талбайгаас үр тариа 13.6 цн, төмс 114.9 цн хураан авсан бол усалгаатай талбайн ургацын улсын дундаж үр тариа 22.3 цн, төмс 116.4 цн хүрчээ.

Зарим аж ахуйн нэгж, иргэд гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа хэрэгжүүлж чадахгүй байгаа тул гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

- *Услалтын системийг шинээр барих зураг төсөл шалгаруулах тендерт шалгарсан Дархан-Уул аймгийн Хонгор сумын УГТЭШХ-ийн талбайн услалтын системд 398.0 сая, “Өглөгчийн хэрэм” ХХК-д 90.0 сая, Хэнтий аймгийн Хэрлэн баян-Улаанд 194.4 сая төгрөгийг ажлын гүйцэтгэл бүрэн гараагүй байхад санхүүжүүлжээ. ХХААХҮЯ гүйцэтгэгч байгууллагууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байхад санхүүжилтийг бүрэн хийсэн байна.*

Хөрөнгө оруулалтын ажлыг тайлан тэнцэлд тусгах, бүртгэх талаар хангалтгүй ажиллаж байна

ХХААХҮЯ болон БОАЖЯ-наас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр тус бүрт хариуцсан ажилтнууд байгаа боловч хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, нэгтгэх асуудал хангалтгүй байна.

- “Агропарк” төслийн хүрээнд олгогдсон тракторыг данс бүртгэлд тусгах асуудал хангалтгүй байна. Тухайлбал, Увс аймагт 6, Баянхонгор аймагт 10, Дорноговь аймагт 5, Булган аймагт 12, Хэнтий аймаг 16 тракторыг сумын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгаагүй байна.
- Хэнтий аймагт 123.7 сая төгрөгийн 13 худаг, 236.3 сая төгрөгийн зоорь, хүлэмж, Дундговь аймагт 360.0 сая төгрөгийн 30 худгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

СС-ын 2008 оны 58 дугаар тушаалаар баталсан “Улсын болон орон нутгийн төсөв, МУХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах” журмын 5.1-дэх заалтын дагуу хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний мэдээг БОАЖЯ болон ХХААХҮЯ сар бүр гаргахгүй байна.

2008 оны хөрөнгө оруулалтын тайланг БОАЖЯ бэлтгэн гаргаагүй бол, ХХААХҮЯ хөрөнгө оруулалтын тайланг буруу гаргасан байна.

Сангийн яамнаас 2008 оны ХАА-ны хэрэгжилтийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд нэгтгэн дүгнэсэн байна. Үүнд: БОАЖЯ-нд 34 хувь буюу “**хангалтгүй**”, ХХААХҮЯ-нд 60 хувь буюу “**хангалттай**” оноо авчээ.

БОАЖ болон ХХААХҮ-ийн салбарын хэмжээнд хийсэн аудитаар аймаг орон нутагт 2836.4 сая төгрөгийн төлбөр, зөрчил илэрснээс 120.4 сая төгрөгт төлбөрийн акт тогтоож, 2716.0 сая төгрөгийн албан шаардлага өгсөн ба ҮАГ-аас хийсэн аудитаар 107.2 сая төгрөгт төлбөрийн акт, 4407.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө.

Дүгнэлт

Бид аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөөгүй, худалдан авалтын журмыг зөв сонгож ажиллаагүй байна.
- Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн үе шат тутамд тавих хяналт хангалтгүй, хийгдээгүй зарим ажлыг хийснээр мэдээлж, санхүүжилтийг бүрэн олгожээ.
- “Агропарк” төслийн хүрээнд хөрөнгийг шаардлагатай судалгаа, тооцоог сайн хийлгүйгээр бүх сумдад хавтгайруулан олгожээ. Бүсчилсэн байдлаар аймаг, сумыг сонгон авч “загвар агропарк” бий болгон бусад сумдад нэвтрүүлэх боломжийг харгалзаж үзэлгүй алдсан байна.
- Хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн барилга, байгууламж, худаг, зоорь, хүлэмж, газар тариалангийн тоног төхөөрөмж, тракторыг данс бүртгэлд авч тайлан тэнцэлд тусгах асуудал хангалтгүй, гэрээний гүйцэтгэлийг үнэлж, хариуцлага тооцохгүй байна.
- Услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах төсөл шалгаруулах хүрээнд татвар төлөгчдийн мөнгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдэд тэднийг дэмжих ямар нэг оновчтой нөхцөл, болзолгүйгээр буцалтгүй тусламж болгон олгожээ.
- Салбарын хэмжээнд хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцох, бүртгэх, тайлагнах, нэгтгэх асуудал хангалтгүй байна

Зөвлөмж

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх нарт:

- ТБОНӨХБАУХАТ хууль, худалдан авах журмыг зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцох;
- Хөрөнгө оруулалтыг бодитойгоор тооцож төлөвлөх, мэдээ, тайланг үнэн зөв гаргах, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний үе шат бүрт тавих дотоодын хяналтыг сайжруулах;
- Салбарын хэмжээнд хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр ашгийг тооцож, дүнг нэгтгэн гаргаж ажиллахын зэрэгцээ тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд:

- Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерт оролцох байгууллагын техник, технологи, ажиллах хүчин, санхүүгийн чадавхи, туршлагыг судлан бодитой үнэлж байх;
- Татвар төлөгчдийн мөнгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдэд буцалтгүй тусламж болгон олгож байгаа бодлого, практикийг эргэн харж, тэднийг дэмжихийн зэрэгцээ, хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, биелүүлээгүй нөхцөлд буцалтгүй тусламжийг зээл болгох, эргэн төлүүлэх зэрэг идэвхижүүлэх оновчтой арга замыг судалж, хэрэгжүүлэх.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд:

- БОАЖ салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг Сайд болон ТНБД-ын тушаалаар шууд гэрээ хийн гүйцэтгэхийг зогсоож, ТБОНӨХБАУХАТ хуулийн дагуу зохион байгуулах;
- Хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэлийг тооцох СС-ын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдлөг болгож ажиллах.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН
ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨШӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД

13351 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайврын ергэн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-26-54
E-mail: mofa@mofa.gov.mn, http://www.mofa.gov.mn


2009.07.02 № 4/2157

танай _____ -ийн № _____ -т

— ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Тус яаманд “Улс төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг уншиж танилцлаа.

Өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу цаашид холбогдох арга хэмжээ авч ажиллана.



САЙД

Т.БАДАМЖУНАЙ

0800782



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД


14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр
Утас: 26-61-71, Факс: (976-11) 26-62-86,
И-мэйл: monenv@mail.mn, http://www.mne.mn

2009.07.02 № 1/1954
танай _____ -ий № _____ -г

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ Б.БАТБАЯР ТАНАА

2008 онд Улс, орон нутгийн төсөв, МУХС,
гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр
хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үйл
ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн
төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төслийг дэмжиж байна.



Л.ГАНСҮХ

080765

Байгаль орчин Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн салбар

(Сая.төгрөгөөр)

2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын			2008 он				Зөрүү		Тайлбар
Эх үүсвэр	Бүтэц	Төсөвт өртөг	Батлагдсан төсөв		Гэрээний дүн	Гүйцэтгэл	Хэмнэлт	Хэтрэлт	
			Хуулиар	Тодотгосон төсөв					
1	2	3	4	5	6	7	8	9	10
Улсын төсөв	Барилга, байгууламж	Шилжиж ирсэн	328,4	278,4	278,4	276,3	276,0	2,4	
		Шинээр эхэлсэн	18 252,4	18 252,4	11 652,5	11 544,5	11 543,4	109,1	
	Их засвар		2 086,4	2 086,4	2 086,4	2 071,4	2 071,4	15,0	
	Тоног төхөөрөмж		6 539,9	6 539,9	5 741,3	5 656,7	5 656,2	85,1	
	Тавилга эд хогшил		86,0	50,0	84,3	84,3	84,3	0,0	
	Бусад		1 748,5	1 748,5	1 748,5	1 721,4	1 720,4	28,1	
	Дүн	29 041,6	28 955,6	21 591,4	21 354,6	21 351,7	239,7	-	
МУХСан	Барилга, байгууламж	Шилжиж ирсэн	-	-	-	-	-	-	
		Шинээр эхэлсэн	7 703,5	-	8 143,5	7 882,8	7 764,6	378,9	
	Их засвар		-	-	-	-	-	-	
	Тоног төхөөрөмж		20 507,0	-	20 507,0	19 180,0	19 180,0	1 327,0	
	Тавилга эд хогшил		-	-	-	-	-	-	
	Бусад		-	-	200,1	200,1	200,1	-	
	Дүн	28 210,5	-	28 850,6	27 262,9	27 144,7	1 705,9	-	
Орон нутгийн төсөв	Барилга, байгууламж	Шилжиж ирсэн	-	-	-	-	-	-	
		Шинээр эхэлсэн	5,0	-	5,0	5,0	5,0	-	
	Их засвар		-	-	-	-	-	-	
	Тоног төхөөрөмж		3,2	-	3,2	3,2	3,2	-	
	Тавилга эд хогшил		5,1	-	5,1	5,1	5,1	-	
	Бусад		7,2	-	7,2	7,2	7,2	-	
	Дүн	20,5	-	20,5	20,5	20,5	-	-	
Гадаадын үйлчилгээ	Барилга, байгууламж	Шилжиж ирсэн	-	-	-	-	-	-	
		Шинээр эхэлсэн	-	-	-	-	-	-	
	Их засвар		-	-	-	-	-	-	
	Тоног төхөөрөмж		135,6	135,6	135,6	88,4	88,4	47,2	
	Тавилга эд хогшил		-	-	-	-	-	-	
	Бусад		-	-	-	-	-	-	
		Дүн	135,6	135,6	135,6	88,4	88,4	47,2	-
	Барилга, байгууламж	Шилжиж ирсэн	-	-	-	-	-	-	
		Шинээр эхэлсэн	48,2	-	48,2	48,2	48,2	-	
	Их засвар		-	-	-	-	-	-	
	Тоног төхөөрөмж		6 430,4	-	6 430,4	3 936,1	3 936,1	2 494,3	
	Тавилга эд хогшил		14,3	-	14,3	14,3	14,3	-	
Бусад		6,2	-	6,2	6,2	6,2	-		
	Дүн	6 499,1	-	6 499,1	4 004,8	4 004,8	2 494,3	-	
Өөрийн хөрөнгө	Барилга, байгууламж	Шилжиж ирсэн	-	-	-	-	-	-	
		Шинээр эхэлсэн	1 265,3	-	1 265,3	1 265,3	1 265,3	-	
	Их засвар		-	-	-	-	-	-	
	Тоног төхөөрөмж		1 036,1	1 002,0	1 036,1	859,1	859,1	177,0	
	Тавилга эд хогшил		40,1	-	40,1	40,1	40,1	-	
	Бусад		663,1	649,0	663,1	663,1	663,1	-	
	Дүн	3 004,6	1 651,0	3 004,6	2 827,6	2 827,6	177,0	-	
Бусад эх үүсвэр	Барилга, байгууламж	Шилжиж ирсэн	-	-	-	-	-	-	
		Шинээр эхэлсэн	1 000,5	1 000,5	1 000,5	977,1	977,1	23,4	
	Их засвар		80,0	80,0	80,0	80,0	80,0	-	
	Тоног төхөөрөмж		439,8	439,8	439,8	439,3	439,3	0,5	
	Тавилга эд хогшил		-	-	-	-	-	-	
	Бусад		820,0	820,0	820,0	817,4	817,4	2,6	
	Дүн	2 340,3	2 340,3	2 340,3	2 313,8	2 313,8	26,5	-	
Бүгд дүн		69 252,2	33 082,5	62 442,1	57 872,6	57 751,5	4 690,6	-	

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ИУХС, ГАДАДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР 2008 ОНД ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ ОРХУУЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН СУДАЛГАА

Салбарын нэр:ХХААХҮЯ,БОАЖЯ
Бэлгэн нэр:.....ГЭМББ

Зөвлөлөгч Д.д Байгууллагын нэр	Хэрэгжүүлэх Хугацаа (онд)	Батлагдсан төсөв /сая төг/	Ашиглалтад ороогүй, комисс хүлээн аваагүй үед санхүүжилт олгосон				Зөрүү /сая төг/	Зураг, төсөвгүй объектын төсөвт өргөг /сая төг/	Гэрээний үүргээ бэлгүүлээгүй байхад		Гүйцэтгэл дутуу байгаа шалтгаан					Тайлбар		
			Хэрэгжүүлэх Хугацаа (онд)		Хэрэгжүүлэх Хугацаа (онд)	Хэрэгжүүлэх Хугацаа (онд)			Хэрэгжүүлэх Хугацаа (онд)	Хэрэгжүүлэх Хугацаа (онд)	Хэрэгжүүлэх Хугацаа (онд)	Хэрэгжүүлэх Хугацаа (онд)	Хэрэгжүүлэх Хугацаа (онд)	Хэрэгжүүлэх Хугацаа (онд)	Хэрэгжүүлэх Хугацаа (онд)			
			дүн /сая төг/	хувь													дүн /сая төг/	хувь
1	2		5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20
1	ХХААХҮЯ	"Агропарк" төслийн хүрээнд зоорь, хулалж байгуулах	2,505.0	1,397.5	55.7	2,505.0	100.0	1,107.5	1,870.0									Улын хэмжээнд 137 сууманд зоорь барьж дуусаагүй, 109 суум хулалжээ хүлээж авсан боловч ашиглалтад оруулаагүй
2	ХХААХҮЯ	Услагын систем шинээр барих	5,200.0	4,072.6	78.3	5,200.0	100.0	1,127.4										Услагын систем шинээр барихад данжлаг болгосон хөрөнгөөс 3 аж ахуйн нэгж 682.9 сая төгрөгийг гэрээнд заасан хуацаандаа ажлаа гүйцэтгээгүй байж бүрэн авсан, 3 аж ахуйн нэгж өмнө нь гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлээр 445.0 сая төгрөг авсан байна.
3	ХХААХҮЯ	Худал, уст цэг шинээр барих	8,000.0	7,578.5	94.6	8,000.0	100.0	433.0										
4	ХХААХҮЯ	ҮТП-ийн оффисын байр худалдан авах	480.0	480.0	100.0	480.0	100.0	480.0										Дархан-Уул, Орхон аймагт худалдан авсан ҮТП ашиглалт хангалтгүй
4	ХХААХҮЯ	Хантуй аймалт сүүний үйлдвэр	200.0			200.0	100.0	200.0										Хөрөнгийн эх үүсвэрийг улаан буудай худалдан авахад зарцуулсан тул эх үүсвэрийг нөхөн бүрдүүлэхээр албан шаардлага өгөв.
5	ХХААХҮЯ	Енж Бордооны техник, тоног төхөөрөмж худалдан авах	500.0			500.0	100.0	500.0										СЯ-наас санхүүжилтийг бүрэн авсан боловч гэрээнд заасан хуацаанд тогтвор нийлүүлээгүй гэж уг хөрөнгийг улаан буудай худалдан авахад зарцуулсан тул эх үүсвэрийг нөхөн бүрдүүлэхээр албан шаардлага өгөв.
6	ХХААХҮЯ	УТС-1804 трактор 110 ширхэгийг нийлүүлэх	4670.0	779.7	16.6	4670.0	100.0	3890.3										
7	БОАЖЯ	Дорноговь аймгийн Хамран хийдийн аялал жуулчлалын цогцлоборын ТУГ-ын жуулчин хүлээн авах мэдээллийн төв	69.9			69.9	100.0	69.9										
8	БОАЖЯ	Завхан аймалт хотийн машин, трактор, электрон-пүү	78.4			78.4	100.0	78.4										Гэрээнд заасан хуацаанд нийлүүлээгүй
10	БОАЖЯ	Барилгат кино	17.5			17.5	100.0	17.5										
			19,213.8	12,910.8	67.2	19,213.8	100.0	7,902.0	1,870.0									
			НИЙТ ДҮН															



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2009 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг."Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн"-д Байгаль орчин, аялал жуулчлал болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэмжээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөрийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав.Аудитын тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх нарт хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2009 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх нарт зөвлөсүгэй.

Тав.Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг энэ онд багтаан Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Ч.РАДНАА

Хуулбар үнэн:

ТАМГЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ

С.ЛХАГВАСҮРЭН

070110

Төсөл

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2009 оны 7-дугаар тушаалын хавсралт

“Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөрийн жагсаалт

(мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Төлбөр хариуцагчийн		Төлбөрийн товч утга	Актын дугаар	Төлбөрийн дүн	Барагдуулалт
	Нэр	Албан тушаал				
ХХААХҮЯ	Т.Гантулга	ТНБД	Хөрөнгө оруулалтын мөнгийг буцааж төвлөрүүлэх тухай	62	44937.7	
	Б.Тунгалаг	Ерөнхий санхүүч				
БОАЖЯ	М.Батсуурь	ТНБД	Төсөвт төвлөрүүлэх тухай	64	62370.0	62370.0
	Д.Цэцгээ	Санхүүгийн хэлтсийн дарга				
Нийт дүн					107307.7	62370.0

